



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 2 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$1,215.6 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 1,215.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 0.6%-иар буюу 7.1 сая ам.доллараар өссөн. Үүнд экспорт 158.6 сая ам.доллараар өсч, импорт 151.5 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60.6% буюу 736.2 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 13.0% буюу 158.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 13.7%-иар өссөн бол ОХУ-тай хийсэн худалдаа 12.6%-иар буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$290.9 сая

Мөнгөн дүн 2015 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 310.2 сая ам.доллараар буурснаар 290.9 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 26.7%-иар өсч, импорт 24.7%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан. Гэвч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү нэмэгдсэн. Улмаар нийт бараа эргэлтийн өсөлт тогтмол түвшинд хадгалагдсаар байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$300.0 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2015 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 300.0 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 283.8 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 23.9%-иар өссөн, импорт 24.7%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.604 (Туршилт тооцоо)


Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.604-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.2%-иар өсч, өмнөх сараас 9.4%-иар буурлаа.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд экспортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1%-иар, импортын үнийн индекс 17.2%-иар буурсан нь нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтад зэсийн баяжмалын үнэ голлон нөлөөлсөн бол импортын үнийн бууралтанд машин, тоног төхөөрөмж, ОХУ-аас импортлож буй нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан зэрэг нь голчлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 2 сар			Өөрчлөлт			
	2015	2014	2013	2015/2014		2014/2013	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	1,215.6	1,208.5	1,317.3	7.1	0.6%	(108.8)	-8.3%
Экспорт	753.2	594.6	506.1	158.6	26.7%	88.5	17.5%
Импорт	462.4	613.9	811.2	(151.5)	-24.7%	(197.4)	-24.3%
Тэнцэл	290.9	(19.3)	(305.2)	310.2		285.9	-93.7%

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 89% + 11%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурч нийт экспортын 89%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 80%, нийт экспортын 71%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 4.0 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 6.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Өсөлт: +26.7%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 26.7%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 20.2%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмалын экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 32%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 40%, 31%, 40%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 19%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 192.4 сая ам.доллараар өссөн бол үнийн өсөлтөөс шалтгаалж 33.8 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 158.6 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмалын үнэ болон тоо хэмжээ, боловсруулаагүй нефть, алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 234 сая ам.доллараар өссөн бол чулуун нүүрсний экспортын тоо хэмжээ буурсан, мөн чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 124 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөнөөр уг бүлгийн экспорт 0.6 сая ам.доллараар өссөн. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 38.0 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2015 оны 2 дугаар сарын 27-ны байдлаар унц тутамд 1,213.2-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 8.5%-иар, өмнөх сараас 5.5%-иар буурсан байна.

А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2015 оны 2 дугаар сарын 27-ны байдлаар 5,924.0, 64.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 6.9%-иар өссөн бол төмрийн хүдрийн үнэ ижил түвшинд хадгалагджээ. Харин өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал зэс 16.3%-иар, төмрийн хүдэр 45.8%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2015			2014			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Дүн	Өсөлт	% 2
1. Ашигт малтмал		668	89%		548	92%	120	↑22%	20.2%
Чулуун нүүрс	1,711	66	9%	2,072	108	18%	(43)	↓-40%	-8%
Зэсийн баяжмал	206	363	48%	123	187	31%	177	↑95%	32%
Төмрийн хүдэр/баяж.	790	47	6%	778	68	12%	(21)	↓-31%	-4%
Боловсруулаагүй нефть	1,219	59	8%	1,004	97	16%	(39)	↓-40%	-7%
Цайрын хүдэр ба баяж.	17	22	3%	12	12	2%	10	↑88%	2%
Мөнгөжөөгүй алт	2,456	98	13%	1,549	63	11%	35	↑56%	6%
Жонш, лейцит, нефелинт	32	8	1%	40	9	1%	(1)	↓-14%	0%
Молибдений хүдэр/баяж	1	6	1%	1	4	1%	1	↑29%	0%
2. Ноос, ноолуур		5.0	1%		4.4	1%	1	↑14%	0.1%
Ямааны угаа.ноолуур	-	-	0%	43	2	0%	(1.5)	↓-100%	-35%
Ямааны сам.ноолуур	51	5	1%	28	3	0%	2	↑75%	49%
3. Бусад		80	11%		42	7%	38	↑90%	6.4%
Нийт дүн		753			595		158.6	↑26.7%	

% - Бүлгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал		170		(50)		120
Чулуун нүүрс	(8)	-44%	(24)	-56%	(43)	-40%
Зэсийн баяжмал	127	72%	50	28%	177	95%
Төмрийн хүдэр ба баяжмал	1	5%	(22)	-105%	(21)	-31%
Боловсруулаагүй нефть	21	54%	(59)	-154%	(39)	-40%
Цайрын хүдэр ба баяжмал	5	52%	5	48%	10	88%
Мөнгөжөөгүй алт	37	104%	(1)	-4%	35	56%
Жонш, лейцит, нефелинт	(2)	-13%	0	3%	(1)	-14%
Молибдений хүдэр ба баяжмал	0	1%	1	86%	1	29%
2. Ноос, ноолуур		0.8		(0.2)		0.6
Ямааны угаасан ноолуур	(15)	-100%	-	0%	(15)	-100%
Ямааны самнасан ноолуур	2.3	109%	(0.2)	-9%	2.1	75%
3. Бусад		21		17		38.0
Нийт		192.4		(33.8)		158.6

Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 34% + 28% +23%

Эхний 2 сарын байдлаар нийт импортын 34%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 28%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 23%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар буурсан бол хэрэглээний бүтээгдэхүүний хувийн жин 3%-иар өссөн байна.

Өсөлт: -24.7%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 15%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт нь 6%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт нь 4%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 42%-иар буюу 92 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 19%-иар буюу 36 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 20.9%-иар буюу 128 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 19%-иар буюу 36 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 11%-иар буюу 11 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 27%-иар буюу 24 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, какао, шоколад болон согтууруулах болон согтууруулах биш ундааны импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 11%-д хүрсэн /Дүрслэл 7/. 2014 оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6 сараас эхлэн буурч, харин сүүлийн саруудад бууралтын хурд багассан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 45%-иар буюу 66 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 37%-иар буюу 19 сая ам.доллараар буурсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 3%-иар буюу 2 сая ам.доллараар буурсан. Уг бууралтын дийлэнх хувийг бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай орцын бүтээгдэхүүн эзэлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 17%-иар буюу 22 сая ам.доллараар буурсан. Нефтийн импорт тоо хэмжээний хувьд 44.7%-иар өссөн боловч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр ийнхүү буурсан байна.

Дүрслэл 8-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай болсон. Гэвч 2013 оны төгсгөлөөс эхлэн дахин буурсан ба 2015 оны 2 сарын байдлаар 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2015		2014		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт	%2
Хэрэглээний бүтээгдэхүүн	157	34%	193	31%	(36)	-19%	-6%
Түргэн эдэлгээтэй	90	20%	102	17%	(11)	-11%	-6%
Хүнс	63	14%	72	12%	(9)	-12%	-4%
Эм, тариа	10	2%	10	2%	(1)	-6%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	18	4%	20	3%	(2)	-11%	-1%
Удаан эдэлгээтэй	67	14%	91	15%	(24)	-27%	-13%
Гутал, хувцас, цүнх	7	1%	9	2%	(3)	-31%	-2%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	18	4%	20	3%	(2)	-10%	-1%
Авто машин, түүний салбэг хэрэгсэл	34	7%	50	8%	(16)	-30%	-8%
Бусад удаан эдэлгээтэй бараа	8	2%	12	2%	(4)	-37%	-2%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	128	28%	221	36%	(92)	-42%	-15%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	80	17%	146	24%	(66)	-45%	-30%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	11	2%	32	5%	(20)	-64%	-9%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	68	15%	114	19%	(46)	-40%	-21%
Барилгын материал	32	7%	51	8%	(19)	-37%	-9%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	17	4%	24	4%	(7)	-30%	-3%
Аж үйлдвэрлэлийн орц	70	15%	72	12%	(2)	-3%	0%
Хүнсний орц	5	1%	3	0%	3	94%	4%
Химийн бүтээгдэхүүн	9	2%	10	2%	(2)	-18%	-3%
Даавуу, утас, арьс, савхин эдгэл	2	0%	2	0%	(0)	-1%	0%
Цахилгаан эрчим хүч	20	4%	16	3%	5	32%	7%
Металлын хүдэр, баяжмал болон хаагдал	0	0%	0	0%	(0)	-62%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	33	7%	41	7%	(8)	-19%	-11%
Нефтийн бүтээгдэхүүн	105	23%	128	21%	(22)	-17%	-4%
Дизель түнш	51	11%	66	11%	(14)	-21%	-11%
АИ-92, АИ-95	40	9%	41	7%	(1)	-2%	-1%
А-80 болон бусад	14	3%	21	3%	(8)	-36%	-1%
Бусад	1	0%	0	0%	1		0%
Нийт дүн	462		614		(152)	-24.7%	

%1 - Булийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
%2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

